



Төрийн Тусгай Албан
Хаагчдын Нэгдсэн Эмнэлэг
Амжилтын төлөө өөрчлөлт

ХУВАНЦАР САВ НИЙЛҮҮЛЭХ ХАРЬЦУУЛАЛТЫН ҮНИЙН САНАЛЫН БАРИМТ БИЧИГ

ШАЛГАРУУЛАЛТЫН ДУГААР:ТТАХНЭ/202012007

УЛААНБААТАР ХОТ
2020 оны 06 дугаар сарын 03-ны өдөр

УРИЛГА

2020 оны 06 дугаар сарын 03-ны өдөр

Үнийн санал шалгаруулалтын нэр: “Хуварцар сав нийлүүлэх”

Үнийн санал шалгаруулалтын дугаар: ТТАХНЭ/202012007

Төрийн тусгай албан хаагчдын нэгдсэн эмнэлгийн тендерт оролцогч эргэж төлөгдөхгүй нөхцөлтэйгээр иж бүрдлээр нь Цахим тендер зохион байгуулах журмын дагуу хураамж 50,000 /тавин мянган/ төгрөгөөр www.tender.gov.mn –ээс оролцох эрхээ худалдан авна. Үнийн санал ирүүлэх барааны техникийн тодорхойлолт болон холбогдох бусад материалыг хавсаргасан болно.

Үнийн саналыг ажлын 7 хоног 2020 оны 06-р сарын 13-ны өдрийн 10 цаг 00 минутаас өмнө худалдан авах ажиллагааны цахим сайт болох www.tender.gov.mn хаягаар ирүүлнэ.

Үнийн саналыг нээлтэд оролцох хүсэлтэй оролцогчдыг байлцуулан **2020 оны 06-р сарын 13-ны өдрийн 10 цаг 30 минутад** нээнэ.

Дотоодны давуу эрх тооцох эсэх: **Тооцно**

Төрийн тусгай албан хаагчдын нэгдсэн эмнэлэг

Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг 4 дүгээр хороо,

Хуульчдын гудамж

Холбоо барих утасны дугаар: 51-262301

Нэг. ОРОЛЦОГЧДОД ӨГӨХ ЗААВАРЧИЛГАА

1. **Эрх бүхий оролцогч ба эрх бүхий бараа**
 - 1.1. Үнийн саналд оролцогч нь “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай” хуулийн 14-16 дугаар зүйл буюу Шалгуур үзүүлэлтэнд заасан холбогдох шаардлагыг хангасан байна.
2. **Үнийн санал ирүүлэх, нээлт**
 - 2.1. Захиалагч нь ирүүлсэн үнийн саналын баримт бичиг Шалгуур үзүүлэлтэнд заасан захиалагчийн хаягаар, заасан огноо, цагаас өмнө хүлээн авна.
 - 2.2. Баримт бичгийг Шалгуур үзүүлэлтэнд заасан хугацаанд, заасан газар нээлтийг хийнэ.
3. **Баримт бичгийн иж бүрдэл**
 - 3.1. Оролцогчийн бэлтгэж ирүүлэх баримт бичиг нь дараах зүйлээс бүрдэнэ. Үүнд:
 - (а) Үнийн санал;
 - (б) Үнийн болон нийлүүлэлтийн хуваарь;
 - (в) Чадварын мэдээлэл /санхүүгийн тайлан, туршлагын мэдээлэл, гэрээ гүйцэтгэсэн ажлын гэрээний хуулбар/ болон бусад баримт бичиг;
 - (г) Шаардлагатай тусгай зөвшөөрөл;
 - (д) Татварын ерөнхий газрын тодорхойлолт
4. **Тогтмол үнэ**
 - 4.1. Оролцогчийн санал болгосон үнэ нь төгрөгөөр илэрхийлэгдсэн байх ба гэрээг хэрэгжүүлэх хугацаанд тогтмол байна. Үнийн тохируулгын нөхцөлтэйгээр ирсэн үнийн саналаас татгалзана.
5. **Техникийн тодорхойлолт ба арилжааны нөхцөлүүд**
 - 5.1. Нийлүүлэх бараа нь техникийн тодорхойлолтын шаардлагыг бүрэн хангасныг оролцогч батлах үүрэгтэй. Нийлүүлэх бараа нь техникийн тодорхойлолтын шаардлагаас зөрсөн тохиолдолд тухайн ирүүлсэн саналаас татгалзана.
 - 5.2. Оролцогч нь энэ баримт бичигт заасан арилжааны нөхцөлүүдийг бүрэн хангасныг албан бичгээр батлан хамт ирүүлнэ.
6. **Үнийн саналын хүчинтэй байх хугацаа**
 - 6.1. Үнийн санал нь түүнийг ирүүлсэн өдрөөс хойш 10 хоногийн хугацаанд хүчинтэй байна.
7. **Санал болгосон үнэ, түүнийг үнэлэх**
 - 7.1. Оролцогч үнийн саналдаа холбогдох бүх даатгал, тээврийн зардал, татвар, хураамжийг оруулж үнийн хуваарийн дагуу ирүүлнэ.
 - 7.2. Бараа нийлүүлэлтийн хуваарьт заасан бараа нь Шалгуур үзүүлэлтэнд заасан багцаас бүрдэх ба багцад орсон нэр төрөл бүрд заавал үнийн санал ирүүлнэ.
 - 7.3. Захиалагч техникийн тодорхойлолт болон бусад нөхцөл шаардлагыг хангасан оролцогчдын үнийг харьцуулж хамгийн бага үнэ санал болгосон оролцогчид гэрээ байгуулах эрхийг олгоно.

**8. Гэрээ
байгуулах
эрх олгох
тухай
мэдэгдэл**

8.1. Захиалагч нь шалгарсан оролцогчид гэрээ байгуулах эрх олгосныг түүний хүчинтэй байх хугацаа дуусахаас өмнө албан бичгээр мэдэгдэнэ. Энэ мэдэгдэлд гэрээнд заасны дагуу хийгдэх ажилд төлөх мөнгөн дүн буюу гэрээний үнийг заана. Гэрээний үнэ нь залруулга болон үнийн хөнгөлөлтийг (түүний дотор нөхцөлтэй үнийн хөнгөлөлт) тооцсон тендерийн үнэ байна.

Хоёр. ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ

ОӨЗ-ны холбогдох заалт	Шалгуур үзүүлэлт
ОӨЗ 1.1	<p>Аудитаар баталгаажуулсан санхүүгийн тайлан ирүүлэх жилийн тоо: 2019 оны санхүүгийн тайланг ирүүлнэ.</p> <p>Сүүлийн нэг жилд хэрэгжүүлсэн ижил төстэй ажил: Сүүлийн 1 жилд гүйцэтгэсэн ижил төрлийн гэрээ ирүүлнэ.</p> <p>Эрх бүхий оролцогч дараах нэмэлт материалыг хавсралтаар ирүүлнэ. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> • Шүүхийн төрөлжсөн архивын тодорхойлолт; • Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын тодорхойлолт; • Татварын цахим тайлангийн системээс авсан тодорхойлолт; • Нийгмийн даатгалын байгууллагын тодорхойлолт; • Хугацаа хэтэрсэн зээлийн өртэй эсэх тухай харилцагч банкны тодорхойлолт; • Бараа нийлүүлэлтийн хуваарь; • Баталгаат хугацаа /баталгаат хугацаат хариуцах гэмтэл, оношлогооны талаар дурдах/ • Худалдагч тал валютын ханшны өөрчлөлт, онцгой албан татвар нэмэгдэх болон гэрээний хугацаанд гарах аливаа асуудлыг бие даан хариуцах ба гэрээний үнэд нөлөөлөхгүй гэсэн албан бичгээр ирүүлэх, Гүйцэтгэгчээр шалгарсан оролцогч барааг техникийн тодорхойлолтын дагуу нийлүүлэх, уг техникийн тодорхойлолтод заасан шаардлагыг бууруулсан талаарх дүгнэлт, хэрэглэгчийн гомдол, шаардлага гарсан тохиолдолд гэрээг цуцалж, дараагийн шаардлага хангасан оролцогчтой гэрээ байгуулахыг зөвшөөрсөн тодорхойлолт; • Үнийн саналын баримт бичгийн гэрээний Ерөнхий болон Тусгай нөхцөл, маягт зэргийг зөвшөөрч байгаа талаар мэдэгдэл ирүүлнэ • Оролцогчийн саналыг олон нийтэд мэдээлэхэд татгалзах зүйлгүй тухай тендерт оролцогчийн мэдэгдэл (Оролцогч байгууллагын нууцад хамаарах мэдээллийг ялган ирүүлэх)
ОӨЗ 2.1	<p>Үнийн санал нээх хугацаа нь:</p> <p>Байгууллагын хаяг: УБ хот, ЧД-ийн 4-р хороо, Хуульчдын гудамж</p> <p>Давхар болон ерөөний дугаар: ТТАХНЭ-ийн 6-р давхар 605 тоот</p> <p>Огноо: 2020 оны 06 дугаар сарын 10-ны өдөр</p> <p>Цаг: 10 цаг 30 минут</p>
ОӨЗ 3.1	<p>Баримт бичгийн талаар тодруулга авах хүсэлтийг хүлээн авах эцсийн хугацаанаас өмнө ажлын 5 хоногоос багагүй байна.</p>
ОӨЗ 3.2	<p>Оролцогчдод өгсөн зааварчилгааны дагуу бэлтгэх ба холбогдох бүх бичиг баримт нь Монгол хэл дээр байна.</p>

ОӨЗ 3.3	Оролцогч Монгол улсын гадна үйлдвэрлэгдсэн бараа нийлүүлэхтэй холбогдуулан үнийг бусад валютаар санал болгон ирүүлэхийг “зөвшөөрөхгүй.”
ОӨЗ 3.4	Барааг нийлүүлсний дараах засвар, үйлчилгээ: “шаардлагатай” 6 сараас доошгүй байх.

Гурав. ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ


Д/д	Нэр төрөл	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Тавигдах шаардлага	Жишиг зураг
1	Хогийн сав	ширхэг	250	15 литрийн багтаамжтай, педалтай, цагаан шаргал эсвэл ногоон өнгөтэй байх	
2	Бохир багаж зөөх сав	ширхэг	62	Урт 50см*өргөн 30см*өндөр 40см хэмжээтэй, сайн чанарын хуванцар байх. Багаж хийхэд хагарахгүй байх ба тагтай, тагны гадна хэсэгт бариултай, шар өнгөтэй байх	
3	Цэвэр багаж зөөх сагс	ширхэг	39	Уян зөөлөн хуванцар материалтай, задгай, бариултай байх. Хэлбэрийн хувьд дөрвөлжин урт 50см*өргөн 30см*өндөр 60см, цагаан өнгөтэй байх	
4	Тарилгын хөвөн зөөх сагс	ширхэг	16	Уян зөөлөн хуванцар материалтай, задгай, бариултай байх. Хэлбэрийн хувьд дөрвөлжин урт 30см*өргөн 10см*өндөр 30см, цагаан өнгөтэй байх	

5	ГХБ диспенсер	ширхэг	112	Хананд суурилуулах боломжтой, суурилуулсан савыг шууд татан авах боломжгүй, уусмал хийх дотроо тусгай савтай, савыг дотор талаас салган авч угаау цэвэрлэх боломжтой, гадна их биед түгжээтэй, цагаан өнгөтэй байх	
6	ӨДС цомгийн сав	ширхэг	56	Урт 30см*өргөн 20см*өндөр 40см хэмжээтэй сайн чанарын хуванцар, цайвар өнгөтэй байх	
7	Эм зөөх сагс	ширхэг	16	Уян зөөлөн хуванцар материалтай, задгай, бариултай байх. Хэлбэрийн хувьд дөрвөлжин, цайвар өнгөтэй байх, урт 80см*өргөн 30см*өндөр 60см байх	
8	Шинжилгээ зөөх сав	ширхэг	43	Үргэлж тагтай, таг бариултай, тунгалаг цагаан өнгөтэй, хуванцар байх. Урт 20см*өргөн 10см*өндөр 20см байх	

9	Поднус халдваргүйжүүлэх хөвөнгийн сав	ширхэг	63	Урт 10см* өргөн10см*өндөр 20см, цайвар өнгөтэй, хуванцар, таг мэдрэгчтэй, эсвэл дарж онгойдог байх	
10	Малгай маск хийх сав	ширхэг	51	Урт 15см* өргөн 5см*өндөр 10см, цайвар өнгөтэй, хуванцар, хананд хадаж суурилуулах боломжтой, дээрээ нүхтэй малгай маск татаж авах боломжтой байх	
11	Яаралтай эм, тариа хийх сав	ширхэг	35	4-5 давхар үетэй, 9-12 тасалгаатай, сайн чанарын хуванцар байх	
12	Өвчтөний эмийн сав	ширхэг	150	Үйлчлүүлэгчийн эмийг савлах зориулалттай, Урт 40см* өргөн 20см*өндөр 20см, цайвар өнгөтэй, хуванцар, тагтай, таг салдаг, түгжигддэг байх	

13	Эм савлах сав	ширхэг	23	6-9 тасалгаатай, сайн чанарын хувцанцар, цайвар өнгөтэй байх	
14	Иж бүрдлийн сав	ширхэг	56	Урт 50см*өргөн 30см*өндөр 40см хэмжээтэй, сайн чанарын хуванцар байх. Багаж хийхэд хагарахгүй ба тагтай, тагны гадна хэсэгт бариултай, цагаан өнгөтэй байх	
15	Канистер	ширхэг	15	Цагаан өнгөтэй, 10 литрийн багтаамжтай байх	
16	Бохир хувцас дарах сав	ширхэг	4	Урт 120см*өргөн 90м*60 40см хэмжээтэй сайн чанарын хуванцар, тайгтай, таг салдаг байх	

17	Хэмжээтэй усны сав	ширхэг	20	3-5 литрийн багтаамж бүхий хэмжээтэй, хүнсний зориулалттай байх	
18	Педалтай хогийн сав	ширхэг	55	25 литрийн багтаамжтай, педал сайтай, дөрвөлжин, урт 50см, өргөн 40см* өндөр 120см, гар өнгөтэй байх	
19	Хүнс хадгалах сав	ширхэг	20	Өндөр 30см* урт 40см *өргөн 20см, олон удаагийн хэрэглээг даах сайн чанарын хуванцар материалтай, хүнсний амт чанарт нөлөөлөхгүй байх	
20	Шал угаагч	ширхэг	30	Дугуйтай, алчуур мушгигчтай, угаах алчууртай, алчуурын сапастай байх	 

21	Дугуйтай хогийн сав	ширхэг	4	<p>Дугуйтай, бат бөх сайн чанарын хувцанцраар хийгдсэн, таг их биетэй холбоотой үргэлж байх ба таг түгжигддэг, чирэх боломжтой байх</p>	
----	---------------------	--------	---	---	---

Дөрөв. НИЙЛҮҮЛЭЛТИЙН ХУВААРЬ

Д/д	Нэр төрөл	Тоо хэмжээ	НИЙЛҮҮЛЭЛТИЙН ХУВААРЬ								
			4 сар	5 сар	6 сар	7 сар	8 сар	9 сар	10 сар	11 сар	12 сар
1	Хогийн сав	250			250						
2	Бохир багаж зөөх сав	62			62						
3	Цэвэр багаж зөөх сагс	39			39						
4	Тарилгын хөвөн зөөх сагс	16			16						
5	ГХБ диспенсер	112			112						
6	ӨДС цомгийн сав	56			56						
7	Эм зөөх сагс	16			16						
8	Шинжилгээ зөөх сав	43			43						
9	Поднус халдваргүйжүүлэх хөвөнгийн сав	63			63						
10	Малгай маск хийх сав	51			51						
11	Яаралтай эм, тариа хийх сав	35			35						
12	Өвчтөний эмийн сав	150			150						
13	Эм савлах сав	23			23						
14	Иж бүрдлийн сав	56			56						
15	Канистер	15			15						
16	Бохир хувцас дарах сав	4			4						
17	Хэмжээтэй усны сав	20			20						
18	Педалтай хогийн сав	55			55						
19	Хүнс хадгалах сав	20			20						
20	Шал угаагч	30			30						
21	Дугуйтай хогийн сав	4			4						

Тав. ЖИШИГ МАЯГТ

1. ҮНИЙН САНАЛЫН МАЯГТ

[огноо]

(Захиалагч байгууллагын нэр)-ын дарга _____ танаа

1. Бид, [оролцогчийн нэр] дор дурдсан барааг [санал болгож буй нийт үнийг тоогоор болон үсгээр] төгрөгөөр үнийн саналын авах баримт бичгийн дагуу [тоо] хоногийн дотор нийлүүлэхээр санал болгож байна.
2. Нийлүүлэх бараа нь техникийн тодорхойлолтын шаардлагыг бүрэн хангасныг гэрчлэх баримтыг хавсаргав.
3. Бид гэрээний ерөнхий болон тусгай нөхцөлийг хүлээн зөвшөөрч байна гэдгийг үүгээр батламжилж байна.

Нэр төрөл	Тодорхойлолт	Барааны гарал үүслийн улс	Тоо ширхэг	Нэгж үнэ	Нийт дүн	НӨАТ болон бусад албан татвар	Бүгд дүн
1	2	3	4	5	6	7	8
Нийт үнэ							

Баталгаат засварын хугацаа:

Санал болгож буй бусад нөхцөл:

Оролцогчийн нэр:

Эрх бүхий албан тушаалтны гарын үсэг, тамга:

Албан тушаал, нэр:

Хаяг:

Зургаа. ӨМНӨ БОЛОН ОДОО ХЭРЭГЖИЖ БУЙ ГЭРЭЭ

Оролцогч хэрэгжүүлсэн болон одоо гүйцэтгэж буй бүх гэрээний талаар мэдээлэл ирүүлнэ.

Уг мэдээлэл нь гэрээ хэрэгжүүлэх чадавхигүй болсон эсхүл ажил дуусгавар болсон гэрчилгээ буюу ажил хүлээлцсэн актаа хүлээн авч байгаа гэрээний хувьд хамаарахгүй.

Гэрээний нэр	Захиалагч, холбоо барих хаяг/утас/фак с	Гэрээний үнийн дүн	Гэрээний эхлэх хугацаа	Гэрээний дуусах хугацаа
1.				
2.				
3.				
4.				
5.				
бусад.				

Долоо. ГЭРЭЭНИЙ ЕРӨНХИЙ НӨХЦӨЛ

- | | |
|---|---|
| 1. Шалгах болон турших | 1.1. Техникийн тодорхойлолтыг хангаж буй эсэхийг баталгаажуулах зорилгоор захиалагч эсхүл түүний төлөөлөгч барааг шалгах, турших эрхтэй. Гэрээний тусгай нөхцөл (ГТН)-д, эсхүл техникийн тодорхойлолтод захиалагч ямар шалгалт, туршилтыг хэзээ, хаана хийхийг заана. |
| 2. Барааны нийлүүлэлт ба баримт бичгийн бүрдүүлэлт | 2.1. Нийлүүлэгдэх бараа нь техникийн тодорхойлолтод нийцсэн байх ба холбогдох стандартыг заагаагүй бол тухайн барааны гарал үүслийн улсын зохих стандартад нийцсэн байна. Үүнд эдгээр стандартын хамгийн сүүлчийн найруулгыг ойлгоно. Нийлүүлэгч ГТН-д заасан бол түүний дагуу тээврийн болон бусад баримт бичгийг бэлтгэж бүрдүүлнэ. |
| 3. Оюуны өмчийн эрх | 3.1. Бараа, эсхүл түүний эд ангийг өмчлөх, ашиглахад патент, худалдааны тэмдэг, зураг төслийн эрх гэх мэт оюуны өмчийн эрхийг захиалагч болон нийлүүлэгч зөрчсөн хэмээн гуравдагч этгээдийн нэхэмжилсэн гомдлыг нийлүүлэгч барагдуулж, холбогдон гарах зардлыг хариуцна. |
| 4. Бараа хүргэх, тээврийн баримт бичиг ирүүлэх | 4.1. Гэрээнд хэрэглэсэн үнэ болон бусад худалдааны нэр томьёог Инкотермс (INCOTERMS) буюу Парис хот дахь Олон улсын худалдааны танхимаас боловсруулж гаргасан сүүлийн хувилбарт тодорхойлсон утгаар ойлгоно. |
| 5. Баталгаат засварын хугацаа | 5.1. Үйлдвэрлэгчийн тухайн бараанд олгодог баталгаат засварын хугацаа <i>[тоо]</i> жил байна. |
| 6. Гэрээнд өөрчлөлт оруулах | 6.1. Гэрээний дагуу нийлүүлэгдэх барааны нэр төрөл, үзүүлэлтийг өөрчлөхгүй. |
| 7. Төлбөр | 7.1. Захиалагч төлбөрийг нэхэмжлэх хүлээн авснаас хойш <i>[ГТН-д заасан тоо]</i> хоногийн дотор шуурхай хийнэ. |
| 8. Бараа нийлүүлэх хуваарь | 8.1. Нийлүүлэгч барааг хүргэхдээ техникийн тодорхойлолтод заасан бараа нийлүүлэлтийн хуваарийг мөрдөнө. |

- 9. Алданги оногдуулах**
- 9.1. Захиалагч нийлүүлэгчийн хугацаа хоцорч нийлүүлсэн бараа, гүйцэтгэсэн үйлчилгээний гэрээний үнийн ГТН-д заасан хувьтай тэнцэх алданги оногдуулж, гэрээний үнийг тэр хэмжээгээр бууруулна. Алдангийн нийт дүн ГТН-д заасан дээд хэмжээнээс хэтрэхгүй.
- 10. Үүргээ биелүүлээгүйгээс гэрээг цуцлах**
- 10.1. Нийлүүлэгч гэрээний үүргээ биелүүлээгүй тохиолдолд захиалагч гэрээг цуцалж, захиалагчид учирсан аливаа хохирлыг нийлүүлэгч барагдуулна.
- 11. Маргааныг шийдвэрлэх**
- 11.1. Талууд гэрээний үүргийн биелэлттэй холбогдсон асуудлаар тохиролцоонд хүрч чадахгүй бол зохих тал шүүхэд нэхэмжлэл гаргана.

Найм. ГЭРЭЭНИЙ ТУСГАЙ НӨХЦӨЛ

- 1. Шалгах болон турших (ГЕН – 1)**
- 1.1. Шаардлагатай тохиолдолд лабораторийн шинжилгээнд хамруулна.
- 2. Барааны нийлүүлэлт ба баримт бичгийн бүрдүүлэлт (ГЕН – 2)**
- 2.1. “Монгол улсын гаднаас санал болгосон бараа: Incoterms 2010 DDP” Шатахууныг жилийн туршид тасралтгүй хангах бөгөөд зах зээл дээр шатахууны хомсдол гарсан нөхцөлд гэрээт байгууллагын үйл ажиллагааг зохих түвшинд хангах шатахууны нөөцтэй байх.
Төрийн тусгай албан хаагчдын нэгдсэн эмнэлгийн ажил, үйлчилгээ эрхэлж буй машин техникт “24” цагийн турш очер дараалалгүй үйлчлэх.
Эмнэлгийн цахилгааны эх үүсвэр тасалдуулахгүй ажиллуулахад генераторын улиралын түлш солих үед зориулалтын тээврийн хэрэгслээр хүргэж үйлчлэх
- Байгууллагын шалгалт туршилтын гэрчилгээ;
Барааны гарал үүслийн гэрчилгээ
- 3. Баталгаат засвар (ГЕН-5)**
- 3.1. Баталгаат засварын тусгай шаардлага.
Нийлүүлсэн бүтээгдэхүүнийг хэрэглэх явцад гарсан гологдлыг тухай бүр шинэчлэн сольж өгнө.
- 4. Төлбөр (ГЕН – 7)**
- 4.1. Гэрээний ерөнхий нөхцөлийн 7 дугаар зүйлийг дараах байдлаар дэлгэрүүлнэ. Үүнд:
- Захиалагч Монгол Улсын гаднаас санал болгосон барааны төлбөрийг нийлүүлэгчид дараах журмын дагуухийнэ.
 - Урьдчилгаа төлбөр: Байхгүй
 - Бараа ачигдсаны дараа төлөх төлбөр: Байхгүй.
 - Барааг хүлээн авахад төлөх төлбөр: 100 хувь /
Барааны төлбөрийг гүйцэтгэлээр нь буюу бараа хүлээн авсанаас хойш 10 хоногийн дотор нэхэмжлэх болон захиалагчийг хүлээн авсан тухай актыг үндэслэн төлнө.
- 5. Алданги оногдуулах (ГЕН - 9)**
- 5.1. Алданги оногдуулах хувь: Хугацаа хэтэрсэн 7 хоног тутамд 0,5%
- 5.2. Алдангийн нийт дүн: 10% иас хэтрэхгүй байна.

Ес. ГЭРЭЭНИЙ МАЯГТ
Гэрээ байгуулахад харилцан тохиролцож өөрчлөлт оруулна.

БАТЛАВ.

ЗАХИАЛАГЧ

НИЙЛҮҮЛЭГЧ

(Тамга, тэмдэг)

(Тамга, тэмдэг)

(Гарын үсэг)

(Гарын үсэг)

(Албан тушаал)

(Албан тушаал)

[Шалгаруулалт/гэрээний нэр] гэрээ.

Дугаар № [Шалгаруулалт/гэрээний дугаар]

.....
хот/аймаг

Нэг талаас **[захиалагчийн нэр]** (цаашид “захиалагч” гэх), нөгөө талаас **[нийлүүлэгчийн нэр]** (цаашид “нийлүүлэгч” гэх) дараах зүйлийг харилцан тохиролцож _____ оны __ сарын ____-ны өдөр энэхүү ГЭРЭЭГ (цаашид “гэрээ” гэх) байгуулав.

1. Монгол Улсын Иргэний болон бусад хууль тогтоомжийн дагуу бараа, бүтээгдэхүүн нийлүүлэхтэй холбогдон захиалагч, нийлүүлэгчийн хооронд үүсэх харилцааг зохицуулах, харилцан хүлээх үүрэг, хариуцлагыг тогтооход энэхүү гэрээний ач холбогдол оршино.
2. Захиалагч нь **[гэрээний нэр, дугаар]**-г (цаашид “бараа” гэх) **[гэрээний үнийг тоогоор болон үсгээр]** (цаашид “гэрээний үнэ” гэх) нийлүүлэхээр ирүүлсэн нийлүүлэгчийн саналыг үүгээр хүлээн зөвшөөрөв. Гэрээний үнэ нь санхүүжилтийн нийт гүйцэтгэл болно.
3. Захиалагч нь барааны нийлүүлэлтийг _____ төгрөгийн улсын төсвийн хөрөнгөөр, _____ төгрөгийн орон нутгийн төсвийн хөрөнгөөр, _____ төгрөгийн өөрийн хөрөнгөөр санхүүжүүлнэ.
4. Нийлүүлэгч _____ нь нэр _____ төрлийн барааг _____ оны __ дугаар сарын ____-наас _____ оны __ дугаар сарын ____-ны өдрийн дотор нийлүүлж хүлээлгэж өгнө.

5. Дор дурдсан баримт бичиг нь гэрээний салшгүй хэсэг болно (цаашид “гэрээний баримт бичиг” гэх). Үүнд:

Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл;
Бусад шаардлагатай баримт бичиг;
Үнийн санал;
Гэрээний тусгай нөхцөл;
Гэрээний ерөнхий нөхцөл;
Техникийн тодорхойлолт болон бараа нийлүүлэлтийн хуваарь;
Санхүүжилтийн хуваарь.

Гэрээ нь энд дурдсан барааны нийлүүлэлтийн талаарх талуудын хоорондын эцсийн тохиролцоо болох ба урьд өмнө үйлдсэн бүх хэлцлийг орлоно. Хэрэв гэрээний баримт бичгүүд хоорондоо зөрчилдвөл дээр дурдсан дарааллын дагуу ач холбогдол өгч шийдвэрлэнэ.

6. Нийлүүлэгч нь энэ гэрээний дагуу захиалагчийн төлөх төлбөрийг үндэслэн энэхүү гэрээний бүх нөхцөл, болзолд нийцүүлэн энд заасан барааг нийлүүлж, гэмтэл согог арилгах үүрэг хүлээнэ.
7. Захиалагч нь гэрээний дагуу нийлүүлэгчийн нийлүүлэх бараа болон гэмтэл согог арилгах үйлчилгээг үндэслэн гэрээний үнэ, эсхүл тухайн үед гэрээний заалтын дагуу төлөх бусад дүнг гэрээнд заасан хэлбэрээр нийлүүлэгчид төлөх үүрэг, хүлээнэ.
8. Гэрээнд холбогдох асуудлаар талууд албан бичгээр буюу шуудан, телекс, цахилгаан болон факсаар харилцана.

ЗАХИАЛАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

НИЙЛҮҮЛЭГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

[Албан тушаал, нэр]

[Албан тушаал, нэр]

*[Гарын үсэг]*_____

*[Гарын үсэг]*_____

ТАМГА

ТАМГА

[Захиалагчийн хаяг]

[Захиалагчийн хаяг]

[Утас/факсын дугаар]

[Утас/факсын дугаар]

[Харилцагч банкны нэр, дансны дугаар]

[Харилцагч банкны нэр, дансны дугаар]